



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 18 дугаар заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 8.1.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2022 оныг "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил" болгон зарласугай.

2. "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" ажлын удирдамжийг нэгдүгээр, "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө"-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталж хэрэгжүүлсүгэй.

3. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбоотойгоор үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагыг нэгтгэх замаар салбарын хэмжээнд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын суурь түвшинг сайжруулж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

4. "Салбарын хэмжээнд чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/514 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141220734

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” АЖЛЫН УДИРДАМЖ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2 дахь зорилтод "Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ" гэж заасан. Үйлчлүүлэгчийн оролцоотой, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд хүргэх нь манай улсын төдийгүй дэлхий нийтийн эрүүл мэндийн байгууллагуудын эрхэм зорилго юм.

Эрүүл мэндийн тусламжийн чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлын асуудалд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ихээхэн анхаарал хандуулж "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үндсэн хэмжигдэхүүн" гэж тодорхойлсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хэн, хаана амьдарч байгаагаас үл хамааран бүхий л иргэд үйлчлүүлэгчийн хувьд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах явцад учирч болох аливаа хохирол, эрсдэлийг 2030 он хүртэл шат дараатайгаар бууруулах замаар тусламж, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2021-2030" хөтөлбөрийг баталсан нь салбарын хэмжээнд чанар, аюулгүй байдлын чиглэлээр баримтлах үндсэн баримт бичиг болж байна. Чанар, аюулгүй байдлын асуудал нь тасралтгүй сайжрах, үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үйл явц байдаг.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2021 оны судалгаагаар 10 үйлчлүүлэгч тутмын 1 нь эмнэлгийн ямар нэг алдаа зөрчилд өртөж, дунд болон бага орлоготой улс орны эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээнээс үүдсэн 134 сая алдааны тохиолдол гарч, жил тутам 2,6 сая эндэгдэлд хүргэж байгаа тухай дурджээ.

Иймд удирдлагын манлайлал, дэмжлэг, зохион байгуулалт хариуцлагыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, олон улсын жишигт ойртуулан хөгжүүлэх нь "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил"-ийн үндэслэл болно.

Хоёр. Зорилго

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд тусламж, үйлчилгээг үр ашигтай, тэгш хүртээмжтэй хүргэхэд удирдлагын манлайлал, дэмжлэгийг нэмэгдүүлэн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг ханган, чанарыг сайжруулах

Гурав. Зорилт

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээн дэх удирдлагын манлайлал, сайн засаглал - Удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх замаар зэмлэн буруутгахгүй дадлыг төлөвшүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх;
2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц - Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах;
3. Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоо - Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ - Эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд салбар дундын хамтын ажиллагааг ханган, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулан, олон улсын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зорилтуудыг хэрэгжүүлэх, тусламж, үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих;
5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмж - Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, эмийн хяналтыг нэгдсэн удирдлагаар хангаж, эмийн чанар, аюулгүй байдлыг сайжруулж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх;
6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт- Иргэн төвтэй хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллага бүрт тусламж, үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэх, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлэх;

Дөрөв. Хугацаа: 2022-2025 он

Тав. Санхүүжилт

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд улсын төсөв, эрүүл мэндийг дэмжих сан, гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудын тусламж дэмжлэгээр хэрэгжүүлнэ.

Зургаа. Хяналт, үнэлгээ

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан холбогдох байгууллагуудыг оролцуулан явцын болон төгсгөлийн үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

Долоо. Шалгуур үзүүлэлт

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа /арга хэмжээ/	Хэмжих нэгж /тоо хэрэгжилтийн хувиар/
1.	Шинэчлэгдсэн хууль эрх зүйн баримт бичиг, заавар, журмын тоо	
2.	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба бүрэн орон тоогоор ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагын тоо	
3.	Тохиолдлын нэгдсэн цахим мэдээллийн санд мэдээлэл илгээсэн байгууллагын тоо	
4.	Мэдээллийн цахим сангаас гарсан зөвлөмж, сэрэмжлүүлгийн тоо	
5.	Үйлчлүүлэгчийг танин тодруулах үйл ажиллагааг нэвтрүүлсэн байгууллагын тоо	
6.	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн хяналт, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	
7.	Олон улсын чанарын баталгаажилт авсан эрүүл мэндийн байгууллагуудын тоо	
8.	Үйлчлүүлэгчийг дэмжих үйлчилгээг нэвтрүүлсэн байгууллагын тоо	
9.	Чанар, аюулгүй байдлын чиглэлээр ажиллаж буй хүний нөөцийг сургалтад хамруулсан удаа, хамрагдсан мэргэжилтний тоо	
10.	Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар зохион байгуулсан арга хэмжээ, түгээн дэлгэрүүлсэн сайн туршлагын тоо	

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 10-ны өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2022-2025 он)

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
ЗОРИЛТ 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээн дэх удирдлагын манлайлал, сайн засаглал - Удирдлагын манлайлалыг нэмэгдүүлэх замаар зэмлэн буруутгахгүй дадлыг төлөвшүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх;										
1.	1.1.Хууль эрх зүйн орчныг сайжруулах	1.1.1.Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулга эмийн чанар, аюулгүй байдлыг хангах заалтуудыг оруулж батлуулах	+			УИХ-ын Нийгмийн бодлогын хорооны ажлын хэсгийн тушаал	УИХ-ын нэгдсэн чуулганаар хуулийн төслийг хэлэлцүүлж батлуулсан байна.	ЭМЯ ЭЭХХЗГ	УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо	
		1.1.2. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хуулийн төсөл боловсруулах	+			Батлагдсан ажлын хэсэг, боловсруулсан хуулийн төсөл	Хуулийн төсөлд яамдын саналыг авсан байна	ЭМЯ	Бусад яам	
		1.1.3. Эд, эс, эрхтэний донорын тухай хуулийн төсөл боловсруулах	+			Батлагдсан ажлын хэсэг, боловсруулсан хуулийн төсөл	Хуулийн төсөлд яамдын саналыг авсан байна	ЭМЯ	Бусад яам	
		1.1.4. Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулах	+			Батлагдсан ажлын хэсэг, боловсруулсан хуулийн төсөл	Хуулийн төсөлд яамдын саналыг авсан байна	ЭМЯ	Бусад яам	
		1.1.5. Сувилахуйн тусламж, үйлчилгээг стратегийн төлөвлөгөөг	+	+		Батлагдсан тушаал	Сувилахуйн тусламж, үйлчилгээг	ЭМЯ	МСЗ	

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
		боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах					хөгжүүлэх стратеги төлөвлөгөө батлагдсан байна.			
		1.1.6.Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөх зарим стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх	+	+	+	+	Стандартын төслийг боловсруулан Стандарт хэмжил зүйн газарт илгээсэн байна.	ЭМЯ	СХЗГ	
	1.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээн дэх сайн засаглал	1.2.1. Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/116,565 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ЭМТҮЧАБ-ын алба/баг/-ыг бүрэн орон тоогоор ажиллуулж үйл ажиллагааг тогтмолжуулах	+	+	+	+	Томилсон тушаал, Хөдөлмөрийн гэрээ	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага	
		1.2.2.Зөвлөн буруутгахгүй аргаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдлын мөрөөр дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авч ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, тасаг нэгжийг урамшуулах тогтолцоог хөгжүүлэх	+	+	+	+	Урамшууллын тогтолцоо бүрдүүлсэн ЭМБ-ын тоо	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх хариу арга хэмжээ авах дадлыг бий болгох	ЭМЯ ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллага

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
		1.2.3.ЭМБ-ын ТУЗ-ын чиг үүрэг, дарга, захирлын албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэл, ёс зүйн асуудлыг тусгах	+	+	+	+	Албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ тусгагдсан байна.	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага	
		1.2.4.ЭМТҮ-ний чанар, аюулгүй байдлын албаны бүтцийг шинэчлэн боловсруулах			+	+	Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал	ЭМЯ	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	
		1.2.5.Эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлын удирдлагын манлайллыг бий болгох, хэрэгжилтийг хянах, үнэлэх тогтолцоо нэвтрүүлж, хэрэгжүүлэх	+	+	+	+	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	ЭМДЕГ, ЭЭХХЗГ, ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага	
		1.2.6. Эрүүл мэндийн чанарын хяналтын орон тооны бус зөвлөл ажиллуулж болох хуулийн заалтыг хэрэгжүүлэх зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах			+	+	Батлагдсан тушаал	ЭМЯ		

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
		1.2.7.Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр урамшууллын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх	+	+	+	+	Шалгуур үзүүлэлт бүхий журам батлагдсан байна.	Эрүүл мэндийн байгууллага		
		1.3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах аян, уралдаан өрнүүлэх, урамшуулах	+	+	+	+	Аян, уралдаанд оролцсон эрүүл мэндийн байгууллагын тоо, тайлан	Эрүүл мэндийн байгууллагууд	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМХТ	
	1.3. Сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх, нутагшуулах	1.3.2. Сайн туршлага хуваалцах орчинг бүрдүүлэх	+	+	+	+	Хэрэгжилтийн тайлан	Эрүүл мэндийн байгууллагууд	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМХТ	
ЗОРИЛТ 2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц - Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах;										
		2.1.1.Цус харвалт, зүрхний шигдээсийн тусламж, үйлчилгээ, хавдрын химийн болон хөнгөвчлөх эмчилгээ, гэмтлийн мэс засал, өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээний чиглэлийн хүний нөөцийг ажиллан суралцах журмын дагуу бэлтгэх,					Сургалтын хөтөлбөр, Сургагдсан, эмч, мэргэжилтний тоо	Сургалт зохион байгуулагдаж мэргэшсэн эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн байна.	ЭМХТ	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн байгууллагууд
2.	2.1. Хүний нөөцийг сургах, чадавхжуулах	2.1.2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч бэлтгэх	+	+	+	+	Сургалтын хөтөлбөр, Сургагдсан ажиллуулсан	Сургалт зохион байгуулагдаж мэргэшсэн мэргэжилтэн	ЭМХТ	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	2.2. ЭМТҮЧАБА-ны хүний нөөцийг мэргэшүүлэх	2.2.1. Чанар, аюулгүй байдлын чиглэлээр чанарын менежер мэргэшүүлэх хөтөлбөрийг сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх, сургалтад хамруулж чадавхжуулах					мэргэжилтний тоо	бэлтгэгдсэн байна.	мэндийн байгууллагууд	
	2.3. Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх	2.3.1. Эмнэлзүйн олон улсын цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, ашиглалтыг үндэслэн эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын багц цагийг дүйцүүлэн олгох	+	+	+	+	Сургалтад хамрагдсан хүний тоо Гэрчилгээ Сургалтын хөтөлбөр	Мэргэшсэн чанарын менежер бэлтгэгдсэн байна.	Сургалт эрхлэгч байгууллага, Эрүүл мэндийн байгууллага	
	2.4. Халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцооны хүний нөөцийг сургах	2.4.1. Өртөлтөөс сэргийлэх арга хэмжээний журмыг тодотгон эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургах	+	+	+	+	Батлагдсан журам	Багц цаг тооцогддог болсон байна.	ЭМХТ	
	2.5. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг	2.5.1. Сувилагчийн ёс зүйн дүрэм батлуулах	+				Эрүүл мэндийн сайдын тушаал	Ёс зүйн дүрэм батлагдсан байна.	Ёс зүйн хяналтын хороо	
		2.4.2.Халдвар хяналтын асуудал хариуцсан ажилтны мэргэжлийн индексийн дагуу хүний нөөцийг бэлтгэх	+	+	+	+	Сургалтад хамрагдсан хүний тоо Гэрчилгээ Сургалтын хөтөлбөр	Өртөлт буурсан байна	МСЗ	
		2.4.1. Өртөлтөөс сэргийлэх арга хэмжээний журмыг тодотгон эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургах	+	+	+	+	Сургалтад хамрагдсан хүний тоо Гэрчилгээ Сургалтын хөтөлбөр	Мэргэшсэн халдвар хяналтын ажилтан бэлтгэгдсэн байна.	Сургалт эрхлэгч байгууллага, Эрүүл мэндийн байгууллага	
		2.5.1. Сувилагчийн ёс зүйн дүрэм батлуулах	+				Эрүүл мэндийн сайдын тушаал	Ёс зүйн дүрэм батлагдсан байна.	Ёс зүйн хяналтын хороо	

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	сайжруулах хөгжүүлэх	2.5.2. Ёс зүйн алдаа, зөрчлийг мэдээлэх бүртгэх тогтолцоог бий болгох		+	+	+	Ёс зүйн алдаа, зөрчлийг мэдээлэх бүртгэх тогтолцоо бүрдсэн байна	ЭМЯ, ЭМХТ	Ёс зүйн хяналтын хороо	
		2.5.3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт зохион байгуулах		+	+	+	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт зохион байгуулагдсан байна	ЭМЯ, ЭМХТ	Ёс зүйн хяналтын хороо	

ЗОРИЛТ 3. Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоо - Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.1. Салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэд, мэндийн байгууллага хооронд мэдээлэл солилцоог хялбаршуулах	3.1.1. Улсын эрүүл мэндийн байгууллагуудад цахимаар цаг захиалах үйлчилгээ болон зарим тодорхойлолт магадлагааг ХУР, E-Mongolia системтэй холбож ашиглалтад оруулах		+			ХУР, E-Mongolia системийг ашиглан үйлчлүүлсэн иргэдийн тоо	Цахимаар цаг захиалах үйлчилгээ болон зарим тодорхойлолт магадлагааг ХУР, E-Mongolia системтэй холбогдсон байна	ЭМЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
	3.1.2. Улсын болон хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагын Эрүүл мэндийн мэдээллийн системийн өгөгдөл солилцоог бүрэн ажиллуулж эхлүүлэх						Өгөгдөл солилцсон эрүүл мэндийн байгууллагуудын тоо	Өгөгдөл солилцдог болсон байна	ЭМЯ
3.2. Эрүүл мэндийн тусламж, нэгдсэн сан	3.2.1. Тохиолдлын мэдээллийн нэгдсэн сан		+	+	+	ЭМТҮЧАБ-ын цахим	Цахим сан бий болсон, сангийн	ЭМЯ ЭМХТ	Аймаг нийслэлийн

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	Үйлчилгээтэй холбоотой тохиолдол мэдээлэх, суралцах тогтолцоог сайжруулах	байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулах					мэдээллийн санд мэдээлэл илгээсэн ЭМБ-ын тоо	ажиллах журам боловсруулсан байна	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага	
	3.2.2	ЭМБ-ын тусламж, үйлчилгээтэй холбоотой аюулгүй байдал алдагдсан тохиолдлыг давтан гаргахгүй байх, түүнээс суралцах орчин бий болгох	+	+	+	+	Мэдээллийн цахим сангаас гарсан зөвлөмж, сэрэмжлүүлэг	Суралцах орчин бүрдсэн байна	ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллага
	3.3. Биетний тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлэх	3.3.1. Эмэнд тэсвэржсэн бичил биетний илрүүлэг, тандалтын тогтолцоог бэхжүүлэх, мэдээллийн урсгалын журам батлуулан хэрэгжилтийг хангах	+	+	+	+	Батлагдсан журам	Журам хэрэгжиж эхэлсэн байна	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага
	3.4. Чанарын баталгаажилтын тогтолцоог бэхжүүлэх, дэмжих	3.4.1. Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж E-Mongolia системд холбох	+	+	+	+	E-Mongolia системд холбогдсон Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо, мэдээлэл	Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа E-Mongolia системд холбогдсон байна.	ЭМХТ	ЭМЯ

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
		3.4.2. Олон улсын чанарын баталгаажилт авсан эрүүл мэндийн байгууллагуудыг бүртгэх	+	+	+	+	Нэгдсэн бүртгэлтэй болсон байна.	ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллага	ОУ-ын стандартын байгууллага	
Зорилт 4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ - Эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд салбар дундын хамтын ажиллагааг ханган, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулан, олон улсын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зорилтуудыг хэрэгжүүлэх, тусламж, үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих;										
4	4.1. Өвчний эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх 4.2. Тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах	4.1.1. Зүрх судасны өвчин – Артерийн даралт ихсэх; Чихрийн шижин, Хорт хавдар, Хүүхдийн хөгжлийн бэрхшээл илрүүлэх эрт илрүүлэг арга хэмжээг зохион байгуулах	+	+	+	+	Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо	Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна.	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага
		4.2.1. Хавдрын хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг орон нутагт үзүүлдэг болох	+	+	+	+	Хавдрын хими хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлдэг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын тоо	Хавдрын хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг орон нутагт үзүүлдэг болсон байна.	ЭМЯ, Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллага
		4.2.2. Амаржих газруудын бүтэц, зохион байгуулалтыг гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхзүйн өөрчлөлттэй уялдуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	+	+	+	+	Амаржих газрын үзүүлж буй тусламж, үйлчилгээний төрөл, тоо	Амаржих газрын тусламж, үйлчилгээний нэр, төрөл нэмэгдсэн байна.	ЭМЯ	ЭМХТ

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
		4.2.3.Пренаталь оношилгоог анхан болон лавлагаа шатлалд нэвтрүүлэх	+	+	+	+	Пренаталь оношилгооны чадавх сайжирсан байна.	ЭМЯ ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллага	
		4.2.4. ДЭМБ-ийн Номхон далайн баруун эргийн бүсээс баталсан "Аюулгүй мэс заслын үйл ажиллагааны хүрээ 2021-2030"-г хэрэгжүүлэх	+	+	+	+	Төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн байна	ЭМЯ-ны ЭТҮГ	ДЭМБ, ММЗЭНХ	
	4.3. Үйлчлүүлэгчийг дэмжих үйлчилгээг сайжруулах	4.3.1.Эмнэлэгт хэвтэхийн өмнөх, хэвтэх үед, эмнэлгээс гарах үеийн дэмжлэг үзүүлэх журам батлуулж хэрэгжүүлэх	+	+	+	+	Журам боловсруулж хэрэгжүүлсэн байна	Эрүүл мэндийн байгууллагууд		
	4.4. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах	4.4.1 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдрийг жил бүр орон даяар тэмдэглэх	+	+	+	+	Дэлхийн өдрийг жил бүр орон даяар тэмдэглэсэн байна	ЭМЯ ЭМХТ Мэргэжлийн нийгэмлэг холбоод	Эрүүл мэндийн байгууллага	
	4.5. Үйлчлүүлэгч, эрүүл мэндийн ажилтныг хамгаалах, дэмжих, аюулгүй	4.5.1.Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг үнэлэх шалгуур боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх	+	+	+	+	Хэрэгжүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	ЭМЯ ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллага	

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	тусламж, үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэх									
	4.6. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг тохиолдлыг бууруулах	4.6.1. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах заавар боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэх 4.6.2. Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх, хүлээлцэх заавар батлуулж, хэрэгжүүлэх	+	+	+	+	Заавар хэрэгжсэн байна.	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага	
	4.7. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн хяналт, үнэлгээг тогтмолжуулах	4.7.1 Эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулах	+	+	+	+	Заавар хэрэгжсэн байна.	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага	
	4.8. Монголын уламжлалт эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах	4.8.1. Монголын уламжлалт засал /зүү, хануур, бумба гэх мэт/ эмчилгээний зааварт үнэлгээ хийж шинэчлэх 4.8.2. Монголын уламжлалт эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр тасралтгүй сургалт зохион байгуулах	+	+	+	+	Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмолжсон байна.	ЭМЯ ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллага	
							Шинэчлэгдсэн заавар	ЭМЯ	МСЗ	
							Сургалт зохион байгуулагдсан байна	ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	МСЗ	

Д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	4.9. Халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоог бэхжүүлэх	4.9.1. Эмнэлгийн зөөлөн эдлэлийн ариутгал, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, 4.9.2. Үйлчлүүлэгчийн хувцас, ор, дэрний даавууны нөөцийг бэлтгэн хэвтэн эмчлүүлэгчийг бүрэн хангах	+	+	+	+	Ариутгал халдваргүйтгэлийн тоног, төхөөрөмжийн тоо Хувцасны тоо, ор дэрний даавуу, зөөлөн эдлэлийн нөөц	Зөөлөн эдлэлийн ариутгал, халдваргүйтгэл сайжирсан байна. Дотоодын нөөцөөр үйлчлүүлэгчийн хувцас, даавууг бүрэн шийдсэн байна.	Эрүүл мэндийн байгууллага	
	4.10. Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах	4.10.1. Эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх гарын авлага, сурталчилгааны материалыг хэвлүүлэх 4.10.2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаар хог хаягдал хариуцсан ажилтан болон эрүүл мэндийн ажилтнуудад ажлын байрны сургалт зохион байгуулах 4.10.3. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын мэдээллийг авах анхан шатны бүртгэл, маягтаар	+				Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаарх гарын авлага, сурталчилгааны материал Сургалтад хамрагдсан байгууллага, хүний тоо	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент сайжирсан байна. Сургалтыг үе шаттай зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн байгууллага ДЭМБ ЭМЯ ХӨСҮТ	Эрүүл мэндийн байгууллага ДЭМБ
				+			Эрүүл мэндийн байгууллагын тоо	Мэдээний сангийн баяжилт хийгдэж хэвшсэн байна.	ХӨСҮТ	Эрүүл мэндийн байгууллага

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
		мэдээний сангийн тогтвортой байдлыг хангуулах								
		4.10.4. ХУД-ийн НЭ-ийг байгальд эзлтэй, нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологийг суурилан шинээр барих		+	+	+	Байгаль орчинд эзлтэй шинэ технологи нэвтрүүлэн туршиж, эрчим хүчний хэмнэлт, үр дүнг тооцсон байна.	ЭМЯ, НЭМГ	ХУД-ийн НЭ, ЭМСХХ-6 төсөл	
ЗОРИЛТ 5. 5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмж - Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, эмийн хяналтыг нэгдсэн удирдлагаар хангаж, эмийн чанар, аюулгүй байдлыг сайжруулж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх;										
5.	5.1.Эмийн хяналтыг нэгдсэн удирдлагаар хангаж, эмийн чанар, аюулгүй байдлыг сайжруулж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх;	5.1.1.Бүх шатны эмийн хяналтын байцаагч болон эм шинжлэх лабораторийг ЭЭХХЗГ-ын харьяанд шилжүүлж, тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллуулах		+			ЭЭХХЗГ-ын харьяанд шилжин ирсэн байцаагч, эм шинжлэгч нарын тоо	ЭЭХХЗГ-аас эмийн чанарын хяналтыг нэгдсэн зохицуулалтаар хангасан байна.	ЭМЯ, ЭЭХХЗГ	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
		5.1.2.Бичил тэсвэржилтээс салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулах					Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна.	ЭМЯ	ХХААХҮЯ	
	5.2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга,	5.2.1. Өндөр өртөгтэй оношилгооны төхөөрөмжийн хэрэглээг хүний нөөцийн			+		Үнэлгээний тайлан, Хамрагдсан ЭМБ-ын тоо, тоног	Өндөр өртөгт оношилгоо, технологи, тоног төхөөрөмжийн ашиглалт, хүний	ЭМЯ ЭЭХХЗГ ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллага

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагаанд хяналт үнэлгээ хийх	хангамжтай уялдуулан хяналт үнэлгээ хийх				төхөөрөмжийн тоо	нөөцийн хангалтын өнөөгийн байдал тодорхойлогдсон байна.			
ЗОРИЛТ 6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт- Иргэн төвтэй хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллага бүрт тусламж, үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчин, нөхцлийг бүрдүүлэх, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлэх										
6	6.1.Иргэн даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог бүрдүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийг дээшлүүлэх	6.1.1.ЭМДҮЗ-ийн 2018 оны 19 дүгээр батлагдсан “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам”-ыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх	+	+	+	+	Батлагдсан тогтоол шийдвэрийн огноо, Эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан дүн	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт хамрагдах насны багц болон журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлсэн байна.	ЭМДЕГ	ЭМЯ, СЭЗГ, ЭМБ-ууд
		6.2.Анхан болон шатлалын эрүүл мэндийн байгууллагын уялдааг бий болгох, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх санхүүжилтийн	6.2.1.ЭМДҮЗ-ийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 04 дүгээр тогтоолыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх	+	+	+	+	Батлагдсан тогтоол шийдвэрийн огноо, Эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан санхүүжилт	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тохиолдолд суурилсан тусламж, үйлчилгээг оношийн хамааралтай	ЭМДЕГ

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	ялгаат байдлыг арилгах						бүлгийн санхүүжилтээр санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.			
	6.3.Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулахад чиглэсэн бодлогыг гаргаж ажиллах	6.3.1.Төрийн эрүүл мэндийн байгууллагаас төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний тушаалыг шинэчилж, эрүүл мэндийн даатгалаас болон иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг тодорхой болгох	+	+	+	+	Батлагдсан тогтоол шийдвэрийн огноо, Төлбөртэй тусламж, үйлчилгээгээс олсон орлогын хэмжээ	ЭМЯ	ЭМДЕГ, Эрүүл мэндийн байгууллагууд	
	6.4.Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох	6.4.1.Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг шат дараалан сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох	+	+	+	+	Орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болсон сумын эрүүл мэндийн төвийн тоо	ЭМЯ	Барилгын хөгжлийн төв	
	6.5.Вакцины хяналтын лабораторитой болгох	6.5.1.Вакцины лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ барих	+				Гүйцэтгэлийн хувь	ЭМЯ	Барилгын хөгжлийн төв	
	6.6. Эх, нярайн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй	6.6.1.Эх хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн "Нөхөн үржихүйн болон Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн	+				Гүйцэтгэлийн хувь	ЭМЯ	Барилгын хөгжлийн төв	

д/д	Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
			2022 он	2023 он	2024 он	2025 он				
	байдлыг нэмэгдүүлэх	барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ барих 6.6.2. "Хүрээ амаржих" газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ барих	+	+			Эх, хүүхдийн чанартай тусламж, үйлчилгээг үзүүлэх ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлсэн байна.	ЭМЯ	Барилгын хөгжлийн төв	
	6.7.Өвчний хяналт, зохицуулалтын төвтэй болгох	6.7.1.Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ барих	+	+			Өвчний хяналт, зохицуулалтын төвтэй болсон байна	ЭМЯ	Барилгын хөгжлийн төв	